

## **Петро Матад Лимитэд ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)-ийн**

### **XX талбайн Өрөмдлөгийн хөтөлбөр**

Петро Матад нь Ди Кью И Интернэшнл компанитай (DQE International (цаашид "DQE" гэх) Матад-XX талбайд хайгуулын хоёр цооног өрөмдүүлэхээр гэрээг байгуулсныг мэдэгдэхэд таатай байна. DQE нь Хятадын Үндэсний Газрын Тосны Корпорацийн Дачин Петролиум Компанийн салбар бөгөөд өрөмдлөг, газрын тосны үйлчилгээг дагнан эрхэлдэг компани юм. DQE нь XX талбайн залгаа байрладаг XIX талбай дээр өрөмдлөг хийж байсан туршлагатай компани юм.

DQE компанийн өрөм одоогоор манай талбайн ойролцоо байгаа бөгөөд эхний цооногийн өрөмдлөгийг нэн даруй эхлүүлэхээр XX талбай руу нүүлгэж байна. DQE компанийн өрөм нь Монгол орны өвлийн хэвийн уур амьсгалд 12 дугаар сарын дунд хүртэл ажиллах боломжтой гэж үзэж байна.

Эхний өрөмдөх цооног нь Давсан Толгой 4 (цаашид "ДТ-4" гэх) юм. Энэхүү өрөмдлөгөөр Давсан Толгойн Үндсэн хэсгээс хагарлаар тусгаарлагдсан Баруун Давсан Толгой<sup>1</sup> хэмээх хэтийн төлөв бүхий талбайд дөрвөн талаасаа хаагдсан гүдэн бүтцийг судална. Баруун Давсан Толгой нь оны эхээр ДТ-1, ДТ-2 болон ДТ-3 цооногуудыг (цаашид "Гурван Цооногийн Хөтөлбөр" гэх) өрөмдсөн Их Давсан Толгойн үндсэн хэсгээс тусдаа талбай юм.

ДТ-4 цооног нь ДТ-1 цооногоос баруун зүгт 3.4 километр, XX ба XIX талбайн хилээс урагшаа 3.7 километрийн зайд байрлах бөгөөд нийт гүн нь 2,020 метр буюу ДТ-1 цооногоос 730 метрээр гүнзгий байх юм.

Баруун Давсан Толгойн Цагаанцавын формацийн эрсдэл тооцоогүй газрын тосны нөөцийг 21 сая баррель, амжилтанд хүрэх магадлал 38 хувь гэж 2010 оны өрөмдлөгөөс өмнө тогтоосон байна.

Энэ жил Их Давсан Толгойд өрөмдсөн гурван цооног бүрийн Цагаанцавын формациас нилээд хэмжээний нүүрсустөрөгч илэрсэн нь уг талбайд нүүрсустөрөгчийн шилжилт болон хуримтлал байгаа эсэх талаархи асуултанд хариу болж эрсдлийг багасгалаа. Мөн эдгээр өрөмдлөгөөр Дээд Зүүнбаянгийн Формаци газрын тос, байгалийн хийн илэрцтэй болохыг тогтоолоо. Ийнхүү энэ жилийн өрөмдлөгийн хөтөлбөрөөр бид Их Давсан Толгойн үндсэн хэсгийн Цагаанцавын Формацийн эрсдэл тооцоогүй 121.5 сая баррелын нөөцөд үнэлгээ өгч, 2010 оны хайгуулын ажлын үндсэн зорилтоо биелүүлэв.

ДТ-4 цооногийг өрөмдсөнөөр бид урьд нь сейсмийн судлагаагаар XX талбайд тогтоогдсон хэтийн төлөв бүхий арван дөрвөн талбайн хоёр дахь талбайд үнэлгээ өгөх юм. Мөн өрөмдлөгөөр Их Давсан Толгойн Үндсэн хэсэгт судлагдсан тосны шилжилтийн хүчин зүйлүүдийг үргэлжлүүлэн судалж, Баруун Давсан Толгойгоос урагшаа болон баруун тийшээ байгаа бусад хэтийн төлөв бүхий талбайнуудад газрын тосны хуримтлал үүсгэх боломжтой эсэхийг тодорхойлно.

2010 онд өрөмдсөн цооногуудын мэдээллээр 3 хэмжээст сейсмийн (чичирхийллийн) судлагааны тайлал болон агуулагч давхаргын эзэлхүүний тооцоог хянаж, улмаар 2011 оны үнэлгээний хөтөлбөрийн загварыг гаргах үндэслэлийг бүрдүүлж байгаа юм. ДТ-4 цооногийн өрөмдлөгийг дуусгаснаар ХХ талбайд тогтоогдсон хэтийн төлөв бүхий бүх талбайгаас олборлох боломжтой гэж гаргасан нийт 882 сая баррель нөөцөөс 142.5 сая баррелыг судалсан байх юм. (Их Давсан Толгойн 121.5 сая баррел болон Баруун Давсан Толгойн 21 сая баррел).

ДТ-4 цооногийн өрөмдлөгийг 12 дугаар сарын дундуур дуусгахаар төлөвлөж байгаа ч Монгол орны өвлийн улирлын дунд үеийн цаг агаарын нөхцлийг урьдчилан таамаглах боломжгүй бөгөөд уур амьсгал эрс хүйтрэх тохиолдол ч байдаг. Тиймээс DQE компанитай байгуулсан гэрээг сунгаж тав дахь буюу ДТ-5 цооногийн өрөмдлөгийг 2010 онд багтаан эхлүүлж болох эсэхийг урьдчилан таамаглах боломжгүй байна.

<sup>1</sup> Зарим тохиолдолд Компанийн баримт бичигт Хойд Давсан Толгой гэж нэрлэдэг байсан.

Мэдээллийг хянан тохиолдуулагч нарын анхааралд:

Петро Матад Лимитэд компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ ("БХГ" гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитэд нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитэд  
Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)  
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитэд  
Ричард Бэти/Питр Нортон  
+44 (0)20 7601 6100